



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 1/25

Жаргалтхаан сум

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн эд хөрөнгийн 2025 оны жилийн эцсийн тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга Э.Батболд (Дотуур байрын багш)

Нарийн бичиг Г.Уранзаяа (Бага ангийн багш)

Гишүүд О.Түвшинбаяр (Нийгмийн ажилтан)


А.Мөнхбат (Багш)

Л.Болдбаатар (Жижүүр)

2. Тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд явуулсугай.

3. Сургуулийн эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай явуулж дуусгах, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, албан хаагчдын эзэмшиж буй эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах, комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тайлан гаргаж ажиллахыг комиссын дарга (Э.Батболд)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



С.ОЮУНЦЭЦЭГ

D/Tushaal-2025
232501049